

Мөнхцоожийн Сугар-Эрдэнэ<sup>1,✉</sup>

<sup>1</sup>Чингис хаан Үндэсний музей  
Монгол улс, Улаанбаатар хот-15160,  
Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж.

### Хадны зураг дахь гахайн дүрслэл

**Товчлол.** Тус өгүүлэлд Монгол орны нутагт буй хадны зураг дахь гахай дүрслэлийн талаар авч үзжээ. Монгол орны баруун хэсгийн хадны зурагт гахайн дүрслэл цөөнгүй тохиолдох ба төв болон өмнөд хэсэгт тун ховор тохиолдож байна. Ингэхдээ Монголын чулуун зэвсгийн үеэс эхлүүлэн түрүү хүрлийн үе, хөгжингүй хүрлийн үе, хожуу хүрлийн үе болон түрүү төмрийн үеийн хүмүүсийн амьдралд гахай чухам ямар ач холбогдолтой байсан, тэд гахайг хэрхэн төсөөлөн дүрсэлдэг байсан талаар өгүүлэв. Ингэхдээ хадны зураг дахь гахайн олон янзын дүрслэлийн он цагийг харьцуулан тодотгохыг чухалчлан үзсэн байна. Хадны зураг дахь гахайн дүрслэлийг зохиомжийн хувьд дөрвөн хэсэгт хуваан үзэв.

**Түлхүүр үг.** Хадны зураг, буган чулуун хөшөө, гахайн дүрслэл, хүрэл зэвсгийн үе, түрүү төмрийн үе

Sugar-Erdene Munkhtsooj<sup>1,✉</sup>

<sup>1</sup> Chinggis Khaan National Museum, J Sambuu street,  
Chingeltei district 4, 15160 Ulaanbaatar, Mongolia

### Depiction of wild boar at Petroglyph

**Abstract.** The article aims to discuss the depiction of pigs in Mongolian petroglyphs. There are a number of depictions of pigs in the petroglyphs of the western part of Mongolia, however, they are very rare in the central and southern regions. In this article, I tried to explain the importance of pigs in the lives of the Mongols in the Stone Age, Early Bronze Age, Late Bronze Age, Iron Age, and Early Iron Age, and how pigs were imagined. It is important to compare and clarify the dates of the various depictions of pigs in petroglyphs. By composition, pigs' depictions are divided into four parts in rock art.

**Keywords.** Petroglyph, Deer stone, depiction of a pig, bronze age period, early iron period

### Удиртгал

Монгол орны нутаг дэвсгэр олон үеийн хадны зургийн дурсгалаар баялаг билээ. Эртний анчин, түүвэрлэгчид хийгээд нүүдэлчдийн үлдээсэн хадны зургийн арвин их дүр дүрслэлийг тусгайлан ялган үзэх нь чухал асуудал юм. Тэдгээр дүрслэлийн дотор тод томруунаар дүрслэгдсэн амьтдын нэг нь гахай байдаг. Ер нь эртний нүүдэлчдийн гахай шүтлэгийн асуудал бүрэн судлагдаагүй сэдэв юм. Зарим судлаачид гахай шүтлэг нэн эртнээс үүсэлтэй бөгөөд голомт нутгийг нь төв Азиас хайх хэрэгтэйг онцлон тэмдэглэсэн зүйл бий [Эрдэнэбат, Амартүвшин, Төрбат 2000: 201]. Чулуун зэвсгийн үеийн анчин, түүвэрлэгчдийн бууц суурины малтлагаас гахайн яс нэлээд гардаг нь түүнийг авлаж хоол хүнсэндээ ашиглаж байсны баримт юм. Мөн гахайг хуучин чулуун зэвсгийн дээд үеэс хад чулуунд бусад амьтдын хамт сийлж зурах болсон бөгөөд энэ уламжлал олон мянган жилийн туршид үргэлжилжээ. Тиймээс энэ өгүүлэлд түүхэн үе бүрд гахайг хадны зурагт дүрслэх онцлог хийгээд холбогдох он цагийн хамаарал, соёлын холбогдлыг тодруулан гаргахыг зорьсон болно.

Өнөөгийн судалгааны түвшинд түрүү төмрийн үеийн нүүдэлчдийн хадны зургийн доторх гахайн дүрслэл нэлээд тодорхой болжээ. Гэвч үүнээс өмнөх үе буюу хуучин чулуун зэвсэг, хүрлийн зэвсгийн үеийн гахайн дүрслэлийн тухай нэг сэдвийн хүрээнд авч үзсэн зүйл алга байна. Тиймээс доор гахайг анх бусад амьтдын хамт хад чулуунаа сийлж зурах болсон хуучин чулуун зэвсгийн дээд үеэс эхлэн улируулан үзэж байна.

### Судалгааны арга зүй

Судлаач өгүүллийн зарим эх хэрэглэгдэхүүнийг хээрийн судалгааны арга зүй ашиглан баримтжуулсан. Ангиртын бэлчир зэрэг өмнө нь эрдэм шинжилгээний эргэлтэд ороогүй хадны зургийн дүрслэлийг гэрэл зургаар буулгаж, түүнийгээ Adobe Photoshop программын тусламжтай гар зураг болгон хувиргав. Баримтыг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон түүхийн шинжлэх ухаан, тэр дундаа хадны зургийн он цаг тогтооход өргөн дэлгэр ашигладаг харьцуулалтын аргыг ашиглав.

### Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Монгол орны хадны зурагт буй олон үед холбогдох гахайн дүрслэлийг энэ өгүүллийг бичих эх хэрэглэгдэхүүн болгон авч үзэв. Түүнчлэн Ангиртын бэлчир дэх хадны зураг нь археологийн мэдээллийн санд шинээр орж буй дурсгал тул түүнтэй холбогдуулан хүрэл зэвсгийн үе, төмрийн түрүү үед хамаарах хадны зураг дахь гахай дүрслэлийн тухай тодотгон үзэх гол шалтгаан болж байна.

Гахай дүрсэлсэн хадны зургийн дурсгалт газрууд: Энэ өгүүлэлд манай орны нутаг дэвсгэрт хадны зургийн 17 дурсгалт газар байх 74 гахайн дүрслэлийг хамруулав. Гахайн дүрслэл нь Монгол орны хадны зургийн цогцолборуудад өмнө нь илэрч, судалгааны эргэлтэд багагүй орж байсан юм. Тухайлбал Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Цагаан Салаа-Бага Ойгор [Цэвээндорж 1999: 47, 86], Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхан, Билүүт, Хойд хөлцөөт [Өмирбек 2019: 46, 47, 100], мөн сумын Далан түргэний хос толгой [Цэвээндорж, Цэрэндагва 2016: 383], Ховд аймгийн Манхан сумын нутаг Ишгэн толгой [Ким Юнгдонг 2008: 376], Мөст сумын нутаг Хойт үзүүр хөх хад [Цэвээндорж 1999: 251], Увс аймгийн Сагил сумын нутаг Хад үзүүр, Зүүнговь сумын нутаг Хар Цагаан усны хад [Цэвээндорж 1999: 46, 52], Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг Шаахар толгой [Цахилгаан 2016: 239, 241], Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг бичигтийн ам [Батболд 2014: 182] зэрэг хадны зургийн дурсгалаас гадна Ханан хад [Ким Юнгдонг 2008: 189], Өмнөд уул [Ким Юнгдонг 2008: 253], Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уул [Баттулга, Анхсанаа 2015:11], зэрэг газарт мөн гахай дүрслэл байгаа ажээ. Эдгээрийг дотор нь он цагийн хувьд ялган үзэх боломжтой юм.

Чулуун зэвсгийн үеийн хадны зураг дахь гахайн дүрслэл: Өнөөгийн судалгааны байдлаар Монгол Алтайн нурууны бүс нутаг чулуун зэвсгийн үеийн хадны сийлмэл зургаар арвин баялаг газар орны нэгэнд зүй ёсоор тооцогдож байна. Дээд палеолитын үеийн анчин, түүвэрлэгчид Алтайд анхны сийлмэл зургийг үлдээснээс хойш олон үеийн туршид гүн гүнзгий утга санаа, олон төрлийн өгүүлэмж зохиомж бүхий хадны зургийн баялаг өвийг үлдээсэн юм.

Алтайн нурууны чулуун зэвсгийн үеийн хадны зургийн үндсэн өгүүлэмж бол ан амьтад билээ. Тэднийг их төлөв бодит байдлаар, сүрлэг дүртэйгээр урласан байдаг бөгөөд гахайн зургийг ч бусад амьтадтай адил бодитоор дүрсэлжээ. Тухайлбал, Ховд аймгийн Манхан сумын нутаг Ишгэн толгойд биеийн ерөнхий тэгийг хөвөөлөн цохихдоо толгой, хүзүү хэсгийг битүү хонхойлоод, цээж болон гэдэсийг холтчин цоохорлосон бодонгийн дүрслэл [Ким Юнгдонг 2008: 376] (Гэрэл зураг 1), Бага Ойгор I талбайд толгойг нь хонхойлоод биеийн бусад хэсгийг нь хөвөөлөн цохисон том бодон, Бага Ойгор II талбайд толгой, бөгсөн биеийг нь хонхойлоод эх биеийг нь хөвөөлөн цохисон гахайн дүрслэл (Гар зураг 1)-ийг сийлсэн арга барилын хувьд хуучин чулуун зэвсгийн төгсгөл үед холбогдуулан үзэх боломжтой юм.

Академич Д.Цэвээндорж абугай Ишгэн толгойн хадны зурагт биеийн ерөнхий тэгийг хүрээлэн цохиж гаргах, бүх талбайг хонхойлон цохих гэсэн үндсэн хоёр арга байгааг тэмдэглээд амьтдыг байгаагаар нь дүрслэхдээ биеийн аль нэг онцлог шинжийг цохон харуулсан тухай дурджээ. Мөн Ишгэн толгойн хадны зураг нь дүрслэлийн арга барил хийгээд зохиомжийн хувьд тус аймгийн нутагт буй Чандмань хар үзүүр, биеийн ерөнхий тэгийг хүрээлэн гаргахдаа аль нэг хэсгийг нь орхигдуулсан байх, мөн аргаль, гөрөөсийн дүрслэл нь Хойт Цэнхэрийн агуйн зосон зурагтай тун ижил байгааг харгалзан эдгээр дурсгалт газар нэг цаг үед холбогдохыг тэмдэглэжээ [Цэвээндорж 1999: 68]. Ишгэн толгойн хадны зураг нь дээрх арга барил зохиомж зэргээрээ дээд палеолитийн үед холбогдохыг ямар ч эргэлзээгүй тэмдэглэсэн ба энд буй бодонгийн дүрслэл нь цаг хугацааны нэг хүрээлэлд багтахыг харуулж байна.

Монгол Алтайн нурууны хадны зургийн томоохон цогцолборын нэг Арал толгойн хаднаа бодит байдлаар дүрсэлсэн үхэр, тэмээн хяруул зэрэг амьтдын хамт 6 гахай (Гар зураг 2)-г дүрсэлсэн байдаг [Цэвээндорж, Кубарев, Якобсон 2005:50, 200]. Эндэхийн зурагт гахайг уртавтар бахим биетэй, богино хөлтэйгөөр ихэд бодитой урлажээ. Ингэхдээ биеийн гадаад тэгийг хөвөөлөн цохих, бүх талбайгаар нь хонхойлох, бөгсөн бие, толгойг битүү хонхойлоод цээжийг хөвөөлөн цохиж дотор нь цоохорлох зэрэг хэд хэдэн аргаар урласан нь анхаарал татаж байна. Ийнхүү нэг амьтныг олон аргаар урласан ч уг амьтны дүрсийг хоорондоо төдийлөн ялгагдахгүй нэг янзаар гаргасан нь харагдаж байна. Зураг дүрслэх олон янзын арга барилаар нэг амьтныг дүрсэлж буй нь тэдгээрийг нэг удаагийн оролдлогоор бүгдийг зураагүй, харин олон удаа дахин давтан олшруулан дүрсэлсэн байх магадлалтай агаад энэ нь эртний анчин, түүвэрлэгчдийн ан гөрөөний олз хишиг бэлгэдсэн агуулгатай байж болох юм.

Арал толгойн хадны зургийг судалсан судлаачид урт хошуугаа дээш өргөн зогссон нэгэн амьтан, түүний хоёр талд буй хүн зэргийг ан гөрөөний сэдэвтэй зохиомж хэмээн үзсэн бөгөөд урт хошуутай тэрхүү амьтныг гахай хэмээн тодорхойлжээ [Цэвээндорж, Кубарев, Якобсон 2005:50]. Харин бид зургийн дүр дүрслэлд тулгуурлан арслан заан (Гар зураг-3) байх магадлалтай хэмээн үзэж буй бөгөөд Монгол Алтайн нурууны Цагаан салаа, Бага Ойгор зэрэг газарт буй арслан зааны зурагтай адил байна. Арал толгойн хадны зургийн холбогдох он цагийн талаар судлаачдын санал зөрүүтэй байдаг. Э.Якобсон Арал толгойн зарим дүрсийг хуучин чулуун зэвсгийн үед холбогдуулан үзээд он цаг тогтоох

таван арга зүйн үүднээс тайлбарласан байдаг [Төрбат нар, 2009:30]. Харин Д.Цэвээндорж абугай энд буй дутуу дүрслээд орхисон бугын зурагт тулгуурлан дэлхийн олон газарт чулуун зэвсгийн үеийн хадны зурагт амьтны дүрсийг дутуу гаргах явдал байсныг онцлон, хуучин чулуун зэвсгийн дээд шатанд холбон үзэх санал дэвшүүлсэн юм [Цэвээндорж, Кубарев, Якобсон 2005:20].

Арал толгойн зурагт голоцены эхэн үед устаж мөхсөн, дайжиж нүүдэллэсэн арслан заан (бидний үзэж буйгаар), тэмээн хяруултай хамт гахайн дүрслэл буй нь он цагийн хувьд нэлээд эрт үед холбогдохыг харуулж байна. Мөн эндэхийн хаднаа дүрслэгдсэн хирс зэрэг амьтны зураг мезолит буюу дунд чулуун зэвсгийн үеийн хадны зурагт тодорхой мэдэгдэхгүй байгаа тул хуучин чулуун зэвсгийн үед холбогдох магадлал илүү өндөр юм. Устаж мөхсөн зарим амьтантай хамт дүрслэгдсэн гахайн зургийг цохиж сийлсэн арга барил, дүрслэлийн хэв маяг нь хуучин чулуун зэвсгийн үед холбон үзэх боломж өгч буй бөгөөд Ишгэн толгой зэрэг бусад газрын ижил дүрслэлтэй нэг цаг үед холбогдох ажээ.

Шинэ чулуун зэвсгийн үеийн хадны зурагт гахайн дүрслэл одоогоор мэдэгдэхгүй байна. Энэ нь хэд хэдэн учир шалтгаантай бололтой. Мөстлөгийн дараах үеийн уур амьсгалын өөрчлөлт хүмүүсийн ахуй амьдралд ихээхэн нөлөөлсөн бөгөөд ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэлтэй холбоотой хадны зургийн дүр дүрслэл, зурах арга барил ихээхэн өөрчлөгдсөн байна. Энэ үеийн хүмүүс их төлөв агуй хонгилын хаднаа улаан зосоор гараа дэлж өргөсөн хүн, сөөлжир чагтан тэмдэг, янз бүрийн тамга тэмдгийн зүйлийг дүрслэх болжээ. Өөрөөр хэлбэл, хуучин чулуун зэвсгийн төгсгөл үеийн амьтны дүрслэлт хадны зургийн өгүүлэмжээс хүн, янз бүрийн тэмдэгтийг зосоор дүрслэх хадны зургийн дүрслэлийн өөр хэв маягт шилжсэн бололтой.

Гэсэн хэдий ч мөстлөгийн дараах үед гахайг хүмүүс хүнс хоолонд ашиглаж байсан баримт Дорнод Монголын Тамсаг булгийн шинэ чулуун зэвсгийн суурины малтлагаар илэрсэн [Бөхчулуун, Одсүрэн, Яанз, 2019]-ээс гадна гахайн соёогоор гоёл чимэглэлийн зүйл хийж хэрэглэж байсныг Дорнод аймгийн Булган сумын нутаг Норовлин уулын булш [Волков, 1975:76-79]-аас илэрсэн эд өлгийн зүйл гэрчлэн харуулж байна.

Эртний гахай шүтлэгийн баримтыг археологийн дурсгалаас шууд ялган танихад төвөгтэй боловч зарим нэг сэжим болох зүйл бий. Норовлин уулын шинэ чулуун зэвсгийн булшинд нас барагчийг дагалдуулан хүний нүүрний дүрст чулуун онго, зуулга иртэй ясан хутга, олон тооны сондор зүүлт, хясаагаар хийсэн цэцэг, амьтны дүрст

чимэглэлүүдтэй хамт 2 ширхэг гахайн дүрстэй танан чимэг олдсон байдаг [Цэвээндорж, 1999:86]. Хүний нүүрний дүрст чулуун онго, дагалдуулсан эд өлгийн зүйл зэрэг нь тухайн булшинд оршуулсан хүн энгийн нэгэн биш гэдгийг илтгэдэг бөгөөд бөө удган байх магадлалтай ажээ.

Гахайн дүрст танан чимгийн бөөрөнд хоёр нүх гарган хувцас зэрэгт хадах зориулалттай хийсэн бөгөөд тэрхүү хоёр нүхний хооронд элэгдэж ховил гарсан нь урт удаан хугацаанд ашиглагдаж байсныг гэрчлэх юм. Уг чимэглэлд гахайг том хоншоортой, богино хүзүүтэй буюу бодит байдлаар дүрслэх чулуун зэвсгийн арга мөн ажиглагдаж байна. Түүнчлэн Норовлингийн булшинд оршуулсан нас барагч энгийн нэгэн гэхээс илүү зан үйлийн холбогдолтой үйл гүйцэтгэдэг хүн байх боломжтой ба түүний хэрэглэж асан эд өлөг ч шүтлэг бишрэлийн агуулгыг тээж байж болох юм.

Ийнхүү шинэ чулуун зэвсгийн үеийн анчин, түүвэрлэгчдийн бууц сууринаас гахайн яс нь бусад амьтны ястай хамт гоёл чимэглэл, хүнс хоолны үлдэгдэл байдлаар илэрдэг бол гоёл чимэглэлийн хувьд булш оршуулгад дагалдуулсан эд өлгийн байдлаар бидэнд мэдэгдээд байна.

Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборуудад бодит байдлаар дүрсэлсэн дээр дурдсан Ишгэн толгой, Цагаан салаа, Бага Ойгор I, II, зэрэг газарт байх гахайн зураг нь дүр дүрслэл, арга барилын хувьд Монгол нутагт буй хамгийн эртний гахайн дүрслэл болохыг бидэнд харуулж байна.

Түрүү хүрлийн үеийн гахайн дүрслэл: Монгол орны хадны зургийн дүрсгалд гахайг их төлөв тайван буйгаар буюу ямар нэг үйл явдлын зохиомжид оруулалгүйгээр дүрсэлсэн байна. Олон гахай дүрсэлсэн хадны зураг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Цагаан салаад бий. Энд нэг хаднаа 11 гахай зурсан байна. Тэдгээрийг бүгд баруун тийш хандсан, тайван байдалтай дүрсэлжээ. Зургийн төвд бусдаас том нэг гахай буй нь бодонг төлөөлүүлэн зурсан байж болох юм. Уг том гахайн дээд талд урт хүзүү, нэлмэгэрдүү хувцас өмссөн хүн урдаа нэгэн жижиг гахайг барьж, газраас хөндийрүүлэн өргөсөн мэт дүрслэл ихээхэн сонирхолтой [Jacobson et al, 2001:229].

Тэдгээрийн ард талд үл танигдах хэдэн амьтны зураг бий. Мөн энд өөр нэг сонирхолтой дүрслэл буй нь тэдгээр гахайн зурагтай хамт соотон чих, толгойгоо ялимгүй доош тонгойлгосон байдалтай, сүүлний үзүүрийг хондлойтой нийлүүлэн зурсан нохойн дүрслэл байх ба сүүлийг дугуйруулаад хондлойд нийлүүлсэн байгаагаас харвал нохой гэж үзэх боломжтой байна. Үл мэдэгдэх хэдэн дүрслэлийг оруулалгүйгээр сүрэг гахай болоод нохой мөн хүний зургийг нэг зохиомж гэж үзвэл, бүх гахайг нэг чигт хандуулан тайван байдалтай

дүрслээд, нохойг сүрэг гахайн зүг харан тайван явж буй, тэдгээр гахайг уг нохойноос үргэж цочсон шинжгүй зурсан нь ан гөрөө гэхээсээ аж ахуйн сэдэвтэй илүү ойр байх магадлалтай юм (Гар зураг-4). Мөн нэг гахайн сүүлийн үзүүрийг дугуйруулан дүрсэлсэн нь сонирхолтой. Алтайн нурууны хадны зурагт үхрийн сүүлийг ийнхүү цул дугуйгаар дүрсэлдэг бөгөөд энэ арга гахайн зурагт мөн ажиглагдаж байна. Цагаан салаагийн дээр дурдсан зурагт гахайг биеийн бүх талбайгаар нь хонхойлон цохих аргаар нэлээд болхидуу үзүүлснээрээ бусад хадны зургаас ялгагддаг. Энэ төрлийн дүрслэл бүхий ан амьтдын зураг тус сумын нутаг Хар ямаа голын хадны зурагт дүрслэгдсэн байна. Энд янгирыг дүрслэхдээ Цагаан салаа дахь олон гахайн адил олонхыг баруун гар тал руу хандуулаад зууван, дөрвөлжин хэлбэрийн их биеийг томоор гаргаж эгц хажуугаас харсан байдлаар үзүүлсэн байна.

Гахайг ингэж урлахдаа дөрвөн хөлийг ихэнх зурагт үзүүлэхийг зорьсон нь мэдэгдэж байна. Ийм бахим зузаан биетэй, дөрвөн хөлтэй зурсан гахайн зураг Бага-Ойгор голын хөндийн хэд хэдэн газраас олдсоныг судлаачид тэмдэглэжээ [Цахилгаан, 2016: 20].

Ийм хэв шинжийн гахайн дүрслэл чулуун зэвсгийн үеийн гахайн зургаас нэлээд ялгаатай. Хуучин чулуун зэвсгийн үеийн хадны зурагт ихэвчлэн хөвөөлөн цохих, биеийн аль нэг хэсгийг нь хонхойлох, холтчих арга барил голлож буйг өмнө өгүүлсэн. Харин Цагаан салаагийн сүрэг гахай дүрсэлсэн хадны зурагт хөвөөлөн цохих бус бүх талбайгаар нь хонхойлох аргыг хэрэглээд дөрвөн хөлийн харуулсан байгаагаар онцлогтой. Түүнчлэн хөгжингүй хүрлийн үе болон хожуу хүрлийн үеийн дүрсгалуудад гахайг болхидуу байдлаар элдэв хэв чимэггүй дээрх шиг дүрслэх арга мэдэгдэхгүй байна. Үүнээс үзвэл, Цагаан салаа дахь олон гахайн дүрслэлийг хуучин чулуун зэвсгийн үеэс хожуу болоод хөгжингүй хүрлийн үеэс өмнөх үед буюу түрүү хүрлийн үед (НТӨ 2600-НТӨ1800) холбогдуулан үзэхэд хүргэж байна.

Хөгжингүй хүрлийн үеийн гахайн дүрслэл: Энэ үед холбогдох гахайн зураг цөөн хэдий ч бидэнд сэжиг болох зарим нэг дүрслэл мэдэгдэж байгаа билээ. Хөгжингүй ба хожуу хүрлийн үеэс гахайг урт хоншоор, соёо, урт нарийн хөлтэй дүрслэх болсон талаар Ц.Төрбат нарын судлаачид дурдаад мөн илүү бодит дүрслэл ч зэрэгцэн оршиж байсан талаар тэмдэглэсэн байдаг [Төрбат нар, 2009:70]. Энэ үеийн хадны зураг нь түрүү хүрлийн үеийн хадны зурагтай харьцуулахад амьтдыг илүү гоёмсгоор чадварлаг сийлсэн хэдий ч тухайн амьтны биеийн ерөнхий шинж, хэлбэрийг мөн харуулахыг зорьсон байна. Үүний нэг жишээ нь



Цагаан салаа, Бага Ойгор дахь гахайн дүрслэл юм. Уг газарт хадны наран ээвэр толигор хэсэгт гурван гахайг арав гаруй тоодог, махчин шувууд болоод буга, хос морь хөллөсөн тэрэг болоод бусад амьтны хамт зурсан байна [Өмирбек, 2019: 106]. Ингэхдээ гахайн их биеийг ямар нэг нэмэлт чимэггүй бодит байдлаар бүх талбайг хонхойлон дүрсэлсэн ба хоёр чихийг соотойлгосон, богино хүзүү, жижиг толгой болоод хоншоорыг усны шувуу адил, хөлийг урт нарийн дүрсэлсэн нь хүрлийн үеийн хадны зургийн нэгэн онцлог гэж судлаачдын тодорхойлсонтой нийцэж байна (Гэрэл зураг 2). Гахайн хоншоорыг газарт хүрсэн байдлаар сийлсэн нь тухайн амьтны биеийн ерөнхий төрхийг харуулахыг зорьсон бололтой. Эртний нүүдэлчид тухайн газар нутагтаа ан элбэг байж, олз омог ивээж байх гэсэн утга бэлгэдлээр хад чулуунаа амьтдын зураг олноор нь сийлдэг байсан хэмээх судлаачдын тайлбар бий.

Хөгжингүй болон хожуу хүрлийн үеэс гахайг урт хоншоор, соёо, урт нарийн хөлтэй дүрслэх уламжлалтай болсон талаар Монгол алтайн археологийн дурсгал номд тайлбарлажээ [Төрбат нар, 2009:70].

Нүүдэлчдийн хадны зургийн нэг гол өгүүлэмж бол ан ав хийж буй сэдэв зохиомж юм. Ихэвчлэн янгир, аргаль, буга зэргийг авлаж буй өгүүлэмж түгээмэл байдаг. Харин гахай авлаж буй зураг тун цөөн бөгөөд Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын хаднаа гахайн автай холбоотой сонирхолтой дүрслэл байдаг.

Дэл уулын нэгэн хаднаа биеийн бүх талбайгаар хонхойлгон дүрсэлсэн 9 гахайг нэг талаас нь нохой дагуулсан хүн үргээж, нөгөө талаас нь мөн нэгэн нохой дагуулаад, нум сум барьсан анчин гахайг авлаж буй байдлаар зохиомжлон дүрсэлсэн байна [Баттулга, Анхсанаа, 2015:11]. Сүрэг гахайг соотон чих, нарийн хөл, дөрвөлжиндүү урт хоншоортойгоор дүрслээд, толгойгоор нь баруун, зүүн тийш харуулан үймсэн байдалтай үзүүлсэн нь үргээлэгт дочин нааш цааш гүйлдэж буйн шинж гэлтэй (Гар зураг-5). Уг зургийн нэг сонирхолтой өгүүлэмж бол “нохойн үргээлэг” юм. Үүнээс үзвэл, нүүдэлчдийн гахай авлах уламжлал нь бүр хүрэл зэвсгийн үеэс эхлэлтэй ба түүндээ нохой ашигладаг байсныг харж болно. Гахай авлахад нэг талаас нохойгоор үргээлгэж, эсрэг талаас нь отоонд суусан анчин агнах тактик өнөө хэр хүртэл чухал ач холбогдолтой байсаар байна.

Дээрх хоёр газар байх гахайн дүрслэлүүд нь ерөнхий хэлбэр болоод биеийн аль нэг хэсгийг (чих) тодотгон харуулахдаа ижилхэн зурсан буй нь ойролцоо цаг үед зурагдсан болохыг илтгэж байна. Бид энэ үеийн хадны зургийн онцлог дүрслэлийн талаар судлаачдын тодорхойлсонтой харьцуулаад дээрх газруудад байх гахайн дүрслэлийг

хөгжингүй хүрлийн үе буюу НТӨ 1800-НТӨ 1200 онд дүрслэгдсэн хэмээн үзэж байна.

Хожуу хүрлийн үеийн гахайн дүрслэл: Хожуу хүрлийн үеэс өнөөгийн Монгол болоод хил залгаа газар нутагт ахуй амьдралын хувьд нэлээд төстэй боловч ертөнцийг үзэх үзэл, сүсэг бишрэл, угсаа гарлын хувьд харилцан адилгүй нүүдэлчид зэрэгцэн оршиж байсан нь булш оршуулга, тахил тайлгын байгууламжийн олон янз байдал, хөшөө чулуу зэргээр тодорхойлогдож байна. Хожуу хүрлийн үеийн томоохон дурсгалын нэг бол хиргисүүр, буган хөшөөний соёл юм. Чухамдаа хиргисүүрийн нүсэр байгууламжийг үлдээгчид хожуу хүрлийн үеийн арвин баялаг хадны зургийн дурсгалыг үлдээсэн бололтой. Хадны зураг дахь амьтдын зарим дүр аажимдаа буган чулуу зэрэг хүнийг төлөөлсөн хөшөө чулуунаа зурагдах болжээ.

Буган чулуун хөшөөнд нэлээд тод томруунаар олон удаа дүрслэгдсэн амьтан бол гахай юм. Гахайг амьтны бодит дүрст болон загварчилсан дүрслэлтэй буган чулуун хөшөөнд том толгойтой, богино хөлтэй, хоншоорыг газарт хүргэн дүрсэлсэн байх бөгөөд одоогоор Архангай аймгийн нутаг Урд хуурайн ам, Баянхонгор аймгийн төв, Булган аймгийн Орхон сумын төв, Говь-Алтай аймгийн Улаан нурууны оцон, Завхан аймгийн нутаг Дунд Шургахын ам, Ховд аймгийн Мөст сумын нутаг Дээд улаан говь, Бодончийн гол, Баянзүрх, Хөвсгөл аймгийн нутаг Хөшөөтийн ам, Зуны гол, Дөрөлжийн ам зэрэг 11 газар 26 гахай дүрсэлснийг тэмдэглэсэн байна [Баярсайхан, 2017:97].

Буган чулуун хөшөөнд гахайг дүрслэхдээ биеийн бүх талбайгаар нь хонхойлох, гадаад тэгийг нь хөвөөлөн цохих уламжлалт хоёр аргаар урлажээ. Үүнээс буган чулуун хөшөөнд хөвөөлөн цохисон гахайн зураг манай орны нутгаас ганц олдсон нь Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хөшөөтийн амны буган чулуун хөшөөнд байна [Баярсайхан, 2017:266].

Евразийн амьтны загварт урлагийн томоохон төлөөлөл болсон буган чулуун хөшөөнөө тогтсон гэмээр дүрслэлийн арга барилаар амьтдыг дүрсэлдэг. Үүнд буга, адууг хамгийн олон дүрсэлсэн байдаг бол тэдгээрийн дараа орох олон давтамжтай дүрслэгдсэн амьтан бол гахай юм. Монгол орны баруун болон умард хэсгийн буган чулуун хөшөөнд гахайн зураг нэлээд олон тааралдаж байна. Хөрш зэргэлдээ орших Саян-Алтайн буган чулуун хөшөөд, Тувагийн хадны зурагт иймэрхүү дүрслэл цөөнгүй буйгаас үзвэл, бодон гахайг чухалчлан үзэх нь нүүдэлчдийн дотор нэлээд өргөн хүрээнд тархсан байжээ.

Саян-Алтайн амьтны бодит дүрст буган чулуун хөшөөнд гахай болон бусад амьтдыг дүрсэлсэн байгаа нь илүү олон байна. Харин Монгол-Өвөр

Байгалийн загварчилсан дүрст буган чулуун хөшөөнд цөөн боловч гахай, адуу, ирвэс янгир, шувуу зэрэг амьтан дүрсэлсэн байдаг ба үүний нэгэн жишээ нь Зуны голын буган чулуун хөшөө юм. Буган чулуун хөшөөнд дээр гахайг бусад амьтдын хамтаар ганц нэгээр дүрслэхээс гадна олноор нь мөн дүрсэлдэг. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг Зуны голын 10-р буган чулуун хөшөөнд 11 гахай дүрсэлсэн байна [Төрбат нар, 2021:143].

Энэ буган чулуун хөшөөнд буй нэгэн сонирхолтой дүрслэл бол хүзүүний зүүлтийн доор, зүүлтээс ялимгүй зайтай (зүүлттэй нийлүүлэлгүй дүрсэлсэн) дээш харуулан урласан жижиг гахайн дүрслэл юм. Судлаач Ж.Баярсайхан дээрх дүрслэлийг тус буган чулуун хөшөөний зүүлтээс унжуулсан сондор хэмээн үзсэн байна. Тэрээр "... Уг хөшөөнд буй амьтад нь хоорондоо тулалдаж буй зохиомжтой бөгөөд бусад гахайн дүрсний дотор бас нэг гахайг дээрх байдлаар дүрсэлсэн нь сонирхолтой юм", гээд дээрх гахайг тулаанд шархдаж үхсэн болохыг илтгэж байж болох юм" гэжээ [Баярсайхан, 2017:98] (Гар зураг-6). Судлаач А.Д.Грач угсаатны зүйн мэдээ баримтад тулгуурлан "хадны зурагт урвуу харуулан дүрсэлсэн амьтад нь үхсэн болохыг илэрхийлдэг" гэсэн санааг дэвшүүлсэн байдаг.

Зуны голын 10-р буган чулуун хөшөөний зүүлтийн доор дээш харуулан дүрсэлсэн жижиг гахайн зургийг сондор гэдэгт бид эргэлзэж байна. Хэрэв сондор бол гахайн нуруунаас сэнж гаргаж зүүлттэй зориуд нийлүүлэн дүрслэх болов уу? Мөн хажууд нь амьтны соёогоор хийсэн сондрыг дүрслэл зүүлтээс унжсан байгааг анхаарах хэрэгтэй юм.

Буган чулуун хөшөөнд сийлэн үлдээсэн голлох амьтан болох буга нь тухайн үеийн хүмүүсийн тотем шүтлэгийн нэгэн дүр мөн болох нь ойлгомжтой.

Харин гахайн дүрийг буга, адууны дараа орох олон тоотойгоор дүрсэлсэн нь эртнээс эхэлсэн гахай дүрслэх уламжлал энэ соёлыг үлдээгчдэд шүтлэг бишрэлийн хэлбэрээр уламжлагдан ирсэн болохыг харуулж байна.

Түүнчлэн судлаачид хадны зураг, буган чулуун хөшөө болон бусад дурсгалын талаар авч үзэхдээ гахайг дүрслэх утга зүйн талаар цухас үзсэн зүйл бий. Судлаач Д.Анхбаяр буган чулуун хөшөөнөө "Гахайг газрын амьтан гэдгийг илт байдлаар дүрсэлсэн гээд" энэ нь утга бэлгэдлийн хувьд доод ертөнцтэй холбоотой [Анхбаяр, 2015:15] хэмээн үзжээ. Үүнийгээ эрт үед хүмүүс далд бүхнийг тэнгэрээс хайдаг байсан бол танин мэдэхүй өргөжихийн хэрээр газар доорх ертөнц болоод бусад зүйлсийн тухай ойлголт урган гарч, улмаар түүнтэйгээ холбон үздэг байсан хэмээн

тайлбарласан байна.

Түрүү төмрийн үеийн гахайн дүрслэл: Энэ үеийн дурсгал нь Монгол орны баруун бүс нутгаар байх Чандмань-Сагил болон Пазырыкын соёлууд юм. Мөн дөрвөлжин булшны соёлын сүүл үе нь түрүү төмрийн үед холбогдох юм. Чандмань-Сагилын соёлд гахайн дүр бүхий гоёл чимэглэлийн зүйл төдийлөн тодорхой мэдэгдэхгүй байгаа бол Пазырыкийн хэмээн нэрлэгдэх соёлд гахайн дүр дүрслэл бүхий хадны зураг цөөнгүй байна. Пазырыкийн үеийн булшнаас гардаг бодон гахайн өвөрмөц дүрсээр баримжаа болгон эдгээрийн он цагийг нарийн тогтоож болох талаар өгүүлсэн байна [Төрбат, Цэвээндорж, 2016: 125]. Судлаачид Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг Шаахар толгой, Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Бичигтийн ам зэрэг газарт байх зарим хадны зургийг энэ үед холбогдуулан үзжээ [Батболд, 2014: 182]. Буган чулуун хөшөөний гахайн дүрслэл түрүү төмрийн үеийн гахайн дүрслэлтэй адил төстэй тал ажиглагдаж байна. Энэ нь өмнөх үеийн урлагийн хэв загвар дараагийн үед дамжин уламжлагдсаныг харуулж байна.

Энэ үеийн амьтны загварт урлагийн нэгэн төлөөлөл болох хадны зурагт нэлээд өөрчлөлт аль хэдийн гарсан талаар харж болохоор байна. Аливаа амьтныг дүрслэхдээ биеийн хэлбэрийг бодит бус, уран сэтгэмжилсэн байдлаар гаргах, үйл хөдлөлд оруулан зохиомжлох, гоёмсгоор урлах зэрэг арга юм. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг дахь Цагаан салаа-Бага Ойгорт энэ үед холбогдох гахайн дүрслэл гурав, Буянт сумын нутаг Хойд Хөлцөөтөд хоёр, Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхны хадны зурагт шавхнуун гэдэс, урт нарийн хөл, дэл зэргийг гоёмсгоор харуулсан гахайн дүрслэл мөн гурав байна. Тус талбарт байх нэг гахайн биеийг бүтэн талбайгаар хонхойлгон цохисон бол нөгөөх хоёр гахайн биеийг олон хэсэг болгон хуваасан ба туурай болоод сага зэргийг тодорхой дүрслэн харуулжээ. Уг дурдсан хадны зургуудыг судлаачид Монгол Алтайн пазырыкийн үед хамааруулан үзэж байна [Төрбат, Цэвээндорж, 2016:119]. Энэ үеийн гахайн дүрслэлд гарч буй нэгэн тодорхой зүйл бол дэл дүрслэх явдал бөгөөд энэ нь хүйс зааж буй нэгэн тэмдэг бололтой. Гахайн гуяны хэсгийг угалзарсан дүрсээр чимэглэсэн байгаа бөгөөд сүүлийг нь урт нарийн гаргаад үзүүрийг дэгээрүүлэн зурсан байгаа нь пазырыкын үеийн хадны зурагт тохиолдох нэгэн чимэглэх арга юм.

Археологийн мэдээллийн санд шинээр бүртгэн оруулж буй Ангиртын бэлчрийн хадны зураг дахь хоёр бүтэн, нэг дутуу дүрсэлсэн гахайн дүрийг бид энэ үед хамруулан үзэж байгаа юм. Уг дурсгал нь Ховд аймгийн Манхан сумын нутаг Ангиртын

бэлчир хэмээх газар оршино. Уг газар байх хүрмэн хадтай уулын өвөр биед сондгой хадны наран эвэр гадар дээр цөөн боловч сонирхолтой дүр дүрслэл бүхий хадны зураг бий.

Гахайг хадны төв хэсэгт буюу зураг зурах ашигтай байрлалд биеийн гадаад тэгийг нь хөвөөлөн цохих аргаар дүрсэлсэн байна. Бүтэн дүрсэлсэн хоёр гахайг тайван идээшилж буйгаар цувуулан сийлжээ. Ерөнхийдөө гахайн биеийг хажуугаас бус, толгой талаас нь ялимгүй жишүү харагдаж буй байдлаар харуулсан. Ингэхдээ урд талд дүрсэлсэн гахай нь газарт туурайгаа хатгасан байдалтай зогссон, түүний хойно дүрсэлсэн гахайг алхаж, хөдөлгөөн хийж буй байдлаар харуулахыг зорьсон бололтой. Гахайн соёог хагас дугуйрсан байдлаар дээш нь матийлгаж, сэрвээн дээр дэл дүрсэлсэн байгааг үзвэл бодон болохыг илтгэнэ. Толгойг ихэд бөхийлгөж хоншоорыг нь газарт шүргүүлэн дүрсэлсэн нь тухайн амьтны биеийн онцлогийг бодит байдлаар харуулахыг зорьж буй бас нэг илрэл байж болох талтай. Гэдэс шавахнуун, гуя нарийн бөгөөд их биеийг олон хэсэг болгон хуваасан нь сонирхолтой юм. Гахайн хөлийг дүрслэхдээ борви болоод туурайг ихэд бодитой гаргасан байна. Амьтны биеийг олон хэсэг болгон хуваах нь хүрлийн үеийн хадны зургийн нэгэн онцлог гэж зарим судлаачид үзсэн байдаг [Төрбат, Цэвээндорж, 2016: 125] ба энэ онцлог арга нь түрүү төмрийн үед мөн уламжлагдаж байсныг харж болохоор байна.

#### Дүгнэлт

Дээр өгүүлсэн хадны зураг, буган чулуун хөшөө, чимэглэх урлагийн холбогдолтой эд өлгийн зүйл нь гахай нэн эртнээс ан гөрөө, зарим газар аж ахуйн хэв шинжтэй байсан болов уу? гэдгийг харуулж байна. Зэрлэг гахайг эртний анчин түүвэрлэгчид хүнс тэжээлийн чухал эх сурвалж болгон ашиглаж байснаас гадна хүч чадлын бэлгэдэл болгож хадны зураг, буган чулуун хөшөөнд олон дүр байдалтайгаар сийлэн үлдээсэн бололтой. Бидэнд буй хэрэглэгдэхүүнд тулгуурлан Монгол орны хадны зураг болон буган чулуун хөшөөнд дүрслэгдсэн гахай дүрслэлийг он цагийн хувьд;

- Чулуун зэвсгийн үе;
- Түрүү хүрлийн үе;
- Хөгжингүй хүрлийн үе;
- Хожуу хүрлийн үе ;
- Түрүү төмрийн үе хэмээн үечлээд тус бүрд нь холбогдох дүр, дүрслэлийн талаар авч үзэв.

Монгол нутагт буй хадны зураг дахь гахайн дүрслэлийг зохиомжийн хувьд;

1. Ан гөрөөний сэдэвтэй (Дэл уулан дахь гахайн дүрслэл);
2. Аж ахуйн холбогдолтой (Цагаан салаа дахь 9 гахайн дүрслэл);

3. Бусад амьтадтай хамт тайван буйгаар (Арал толгой, Цагаан салаа, Бага Ойгор г.м);

4. Шүтлэг бишрэлийн холбогдолтой (Буган чулуун хөшөөн дэх гахайн дүрслэл); дүрсэлсэн гэсэн 4 хэсэгт хуваан үзэж байна.

Үүнд шүтлэг бишрэлийн холбогдолтой дүрслэлд буган чулуун хөшөөн дэх гахайн дүрслэлийг хамааруулан үзэж байна. Буган чулуун хөшөө нь хүнийг төлөөлүүлсэн дурсгал гэдгийг судлаачид тогтоогоод байгаа бөгөөд түүнд тотем амьтан болох зарим амьтдыг бэлгэдлийн шинж чанартай дүрсэлдэг билээ. Энэ утгаар авч үзвэл, гахай тухайн үеийн тотем шүтлэгийн нэг тод томруун дүр байх боломжтой юм.

Дээр дурдан буй хадны зураг болоод буган чулуун хөшөө, оршуулгын зан үйл, гоёл чимэглэлд гахайтай холбоотой мэдээ баримт арвин байгаа нь хүн төрөлхтөн эртнээс нааш гахайг чухалчлан үзэж байсны баримт ба хүнс тэжээлийн чухал эх сурвалж болж байсны давхар нотолгоо юм.

#### Ном зүй

**Анхбаяр 2005** - Анхбаяр Д. Буган чулуун хөшөөн дэх дүрслэлийн утгазүйн асуудалд. //УБ-ын ИС-ийн НУФ-ийн эрдэм шинжилгээний бичиг №2(1), УБ., 2005.

**Батболд 2014** – Батболд Н. Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа. УБ., 2014

**Баттулга, Анхсанаа 2015** - Баттулга Ц., Анхсанаа Г. Дэл уулын түүх, соёлын дурсгал. УБ., 2015

**Баярсайхан 2017** - Баярсайхан Ж. Монголын умарт нутгийн буган хөшөөд. УБ., 2017

**Волков 1975** – Волков В. В. Погребенние в Норовлин уула (Монголия) // Археология Северной и Центральной Азии. Наука, 1975

**Ким Юнгдог 2008** - Редактор Ким Юнгдог. Монголын Говь-Алтайн хадны зураг, Дунбока түүхийн сан, ШУА-ийн Археологийн хүрээлэн., 2008

**Одсүрэн, Яанз, Бөхчулуун 2019** - Одсүрэн Д., Яанз Л., Бөхчулуун Д. Монгол-Канадын хамтарсан говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа төслийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. УБ., 2019. ШУА-ийн АХГБСХ.

**Өмирбек 2019** - Өмирбек Б. Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалууд. УБ., 2019

**Төрбат нар., 2009** - Төрбат Ц., Баяр Д., Цэвээндорж Д., Баттулга Ц., Баярхүү Н., Идэрхангай Т., Жискара П.Х. Монгол алтайн археологийн дурсгалууд-1 Баян-Өлгий аймаг. УБ., 2009

**Төрбат, Цэвээндорж 2016** - Төрбат Ц., Цэвээндорж Д. Монгол Алтайн мөнх цэвдгийн булш, монголын пазыркийн соёл. УБ., 2016.

**Төрбат нар., 2021** - Төрбат Ц., Гантулга Ж., Баярхүү Н., Батсүх Д., Эрдэнэ-Очир Н., Батболд Н., Энхбаяр Г., Идэрхангай Т. Монгол ба бүс нутгийн буган хөшөөний соёл III боть. УБ., 2021

**Цахилгаан 2016** - Эмхэтгэсэн Цахилгаан Д. Монгол алтайн чулуун шастир. УБ., 2016.

**Цэвээндорж 1999** - Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх. УБ., 1999

**Цэвээндорж, Кубарев, Якобсон 2005** - Цэвээндорж Д., Кубарев В.Д., Якобсон Э. Арал толгойн хадны зураг. УБ., 2005

**Эрдэнэбат, Төрбат, Амартүвшин 2000** - Эрдэнэбат У., Төрбат Ц., Амартүвшин Ч. Монголчуудын гахай шүтлэгийн тухай асуудалд. Сибирь болон Монголын ард түмний угсаатны зүй. УБ-Улаан-Үд., 2000

**Jacobson et al 2001** - Esther Jacobson., Vladimir Kubarev., Damdinsurenjin Tseveendorj. Mongolie du Nord-Ouest Tsagaan Salaa/Baga Oigor. Répertoire des Petroglyphs d'Asia Centrale. Tome V. Fasc. 6. Paris 2001


Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 08 сарын 14

Өгүүлэл засварласан: 2023 оны 11 сарын 06


Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 12 сарын 01



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.




Гар зураг 1. Бага-Ойгорын хадны зураг  
[Якобсон нар 2001]




Гар зураг 2. Арал толгойн хадны зураг.  
[Арал толгойн хадны зураг номоос]





Гар зураг 3. Арал толгойн хадны зураг.  
[Арал толгойн хадны зураг номоос]



Гар зураг 4. Цагаан салаан хадны зураг  
[Якобсон нар 2001]



Гар зураг 5. Дэл уулын хадны зураг  
[Б.Батмөнхийн гэрэл зургаас  
дахин зурж буулгасан хувилбар]



Гар зураг 6. Зуны голын буган чулуун хөшөө  
[Ж.Баярсайханы гар зураг]



Гэрэл зураг 1. Иишгэн толгойн хадны зураг  
[Монголын Говь-Алтайн хадны зураг номоос]



Гэрэл зураг 2. Цагаан салаа-Бага Ойгорын хадны зураг  
[Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалууд номоос]